

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЗӨВЛӨЛ

Үйл ажиллагааны нэгдсэн тайлан **2023**

ӨМНӨТГӨЛ

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЗӨВЛӨЛ (ХМЗ) НЬ:

- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг дэмжих;
- Нийгэмд сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын эгэх хариуцлагыг бэхжүүлэх;
- Сэтгүүл зүйн бүтээлийн ёс зүй болон мэргэжлийн стандартыг хөгжүүлэх;
- Хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг хамгаалах зорилгын дор үйл ажиллагаа явуулдаг сэтгүүлч, ажил олгогч, салбарын эвсэл холбоод, мэргэжлийн байгууллагуудын санаачилга, амжилттай хамтын ажиллагааны үр дүнд 2015 оны эхээр байгуулагдсан хэвлэмэл, цахим, радио, телевизийн хараат бус, өөрийн зохицуулалтын байгууллага юм.

2023 онд Хэвлэл мэдээллийн зөвлөл нь хэвлэл мэдээллийн байгууллага, редакцын мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, иргэн, байгууллага аж ахуйн нэгжээс редакцын нийтлэл, нэвтрүүлэгт гаргасан өргөдөл гомдлыг барагдуулах үндсэн чиг үүргээ амжилттай хэрэгжүүллээ.



2023 онд ХМЗ-д иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 33 өргөдөл гомдол ирүүлснийг Ёс зүйн хороод 7 удаагийн хурлаар хэлэлцэн шийдвэрлээд байна.



ХМЗ-ийн Удирдах зөвлөл хэвлэл мэдээллийн эрх зүйн орчныг сайжруулах, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг бэхжүүлэх, хараат бус байдлыг хангах, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын үйл ажиллагаанд чанарын удирдлагыг нэвтрүүлэх зэрэг бодлогын шийдвэрүүдийг гаргаж ажиллаа.



Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт, ёс зүйн зарчим, чанарын удирдлага зэрэг сэдвийн хүрээнд ХМЗ-ийн гишүүд, ажлын албанд бүх гишүүдийн сургалт 1 удаа, УЗ-ийн гишүүдийн зөвлөлдөх уулзалт 2 удаа, Ёс зүйн код шинэчлэх ажлын хэсгийн уулзалт 2 удаа, ССС-ын Ёс зүй хороо, ХБНГУ-ийн Хэвлэлийн зөвлөлийн орлогч дарга, “Дойче веллэ” академийн сургагч багш Манфред Протцетэй зөвлөлдөх уулзалт 1 удаа тус тус хийж хэвлэл мэдээллийн байгууллага/редакцуудад 3 удаагийн уулзалтыг зохион байгууллаа.



Сэтгүүл зүйн чанарын тухай хэвлэл мэдээллийн салбарынхан болон олон нийтэд зориулсан 50 орчим сургалт, уулзалт, хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулж, 1000 гаруй хүнд хүрч ажиллажээ.



Хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байх бодлогын хүрээнд 4 удаагийн цахим сэтгүүлийг Монгол, Англи хэлээр бэлтгэн улирал тус бүр 1400 гаруй хүнд тогтмол хүргэлээ. Мөн сэтгүүл зүйн чанарыг дэмжих бодлого, зорилгын хүрээнд “Бидний подкаст” нэртэй цуврал подкастыг эрхлэн бэлтгэлээ. Түүнчлэн өдөр тутмын үйл ажиллагааг вэб сайт, олон нийттэй харилцах цахим хуудсаараа дамжуулан түгээж байна.



Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл, Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбоо, Орон нутгийн ТВ-үүдийн холбоо, Парламентын сэтгүүлчдийн холбоо, Монголын гэрэл зурагчдын нэгдсэн холбоо, Глоб интернэшнл төв, Хэвлэлийн хүрээлэн, Нээлттэй нийгэм форум, Монголын Эмнести Интернэшнл, Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв, Сэтгүүл зүйн Инноваци, Хөгжлийн Үүр төв зэрэг салбарын эвсэл, холбоод болон дотоод, гадаадын түншлэгч байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, Төв Азийн Хэвлэлийн зөвлөлүүдийн сүлжээнд нэгдэв. Мөн “Өөрчлөлтийн дуу хоолой” төслийг хэрэгжүүлснээр Европын холбоотой хамтын ажиллагаагаа эхлүүлээ. “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдлийн үйл ажиллагааны хүрээнд Тунгаахуй өгөгдлийн урлан, Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд, Сонгогчдын боловсрол төв зэрэг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллав.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ

Хэвлэл мэдээллийн зөвлөл нь хоёр Ёс зүйн хороотойгоор үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд тус хороод нь иргэн, байгууллагаас ирүүлсэн гомдлыг ХМЗ НҮТББ-ын дүрэм, Үйл ажиллагааны журам, Гомдол хүлээн авах, барагдуулах журам, Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчимд тулгуурлан хэлэлцэж дүгнэлтээ гаргадаг.

Хэвлэл мэдээллийн зөвлөл НҮТББ нь нийт 45 гишүүнтэй. Зөвлөлийн дүрмийн дагуу салбар бүрийн төлөөлөл тэгш тооны квоттой бөгөөд бүтцийн схем нь тус зөвлөлийн олон талт оролцоог тэгш хангах, аливаа ашиг сонирхлын бүлгийн нөлөөллөөс ангид байх хараат бус байдлын баталгаа болдог. Тодруулбал, эздийн төлөөлөл 18, сэтгүүлчдийн төлөөлөл 18, харин олон нийтийн төлөөлөл 9 байдаг. Эдгээр 45 гишүүн нь бие даасан гурван бүлэгт дараах байдлаар хуваагддаг.



УДИРДАХ
ЗӨВЛӨЛ
15 гишүүн



СОНИН, СЭТГҮҮЛ, САЙТЫН
ЁС ЗҮЙН ХОРОО
15 гишүүн



РАДИО, ТЕЛЕВИЗ, САЙТЫН
ЁС ЗҮЙН ХОРОО
15 гишүүн


АЖЛЫН АЛБА 10 АЖИЛТАНТАЙ:



ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ХҮЛЭЭН
АВАХ БАРАГДУУЛАХ НЭГЖ
4 хүн



ТӨСЛИЙН
НЭГЖ
6 хүн





НӨХӨН СОНГУУЛЬ:

- Хэвлэл мэдээллийн зөвлөлийн Ёс зүйн хорооны дүрмийн 9.4, 9.7-д заасны дагуу нөхөн сонгуулийг нээлттэй зарын дагуу зохион байгуулж, хүсэлтээ илэрхийлсэн төлөөллийн квотыг хангах шинэ гишүүдийг сонголоо. Тодруулбал, РТВ-ийн ёс зүйн хороонд сайтын сэтгүүлчийн төлөөллөөр Urug.mn сайтын сэтгүүлч У.Болортуяаг, Сонин, Сэтгүүл, Сайтын ёс зүйн хороонд олон нийтийн төлөөллөөр хуульч, чөлөөт судлаач Л.Галбаатарыг тус тус зургаан жилийн хугацаагаар сонгов.



РТС-ын Ёс Зүйн Хороо



ССС-ын Ёс Зүйн хороо

Мөн энэ үеэр РТВ-ийн ёс зүйн хороонд радио, телевизийн эздийн төлөөллөөс сонгогдсон Г.Бат-Эрдэнэ, олон нийтийн төлөөллөөс сонгогдсон Т.Өнөрсайхан, СССР-ын Ёс Зүйн хороонд сайтын сэтгүүлчийн төлөөллөөс сонгогдсон Ш.Оюунчимэг нарын хүсэлтийг харгалзан үзэж, ХМЗ-ийн Ёс зүйн хорооны гишүүнээс чөлөөллөө.

- ХМЗ-ийн Сонин, Сэтгүүл, Сайт /ССС/-ын Ёс зүйн хорооны 2023 оны гуравдугаар улирлын хурлаар хорооны дарга, орлогч даргаа сонголоо. Тус хорооны даргаар хэвлэмэл хэвлэлийн сэтгүүлчийн төлөөллөөс сонгогдсон сэтгүүлч Х.Болормааг, орлогч даргаар олон нийтийн төлөөллөөс сонгогдсон хуульч, судлаач Л.Галбаатарыг сонголоо.



Сонин, сэтгүүл, сайтын
Ёс зүйн хорооны гишүүн
Х.Болормаа

Х.Болормаа нь Хэвлэл мэдээллийн зөвлөлийг үүсгэн байгуулсан анхны гишүүдийн нэг бөгөөд найман жилийн туршид СССР-ын Ёс зүйн хорооны гишүүнээр ажилласан туршлагатай юм. Тэрээр 200 гаруй өргөдөл гомдлыг шийдвэрлэхэд оролцож, ХМЗ-ийн гишүүдийг чадавхжуулах 15 удаагийн сургалтад хамрагдаж, 2015 онд Германы хэвлэлийн зөвлөлд очиж туршлага судалснаас гадна сүүлийн нэг жилийн хугацаанд тус хорооны даргын үүрэг гүйцэтгэгчээр ажилласан билээ.


НЭГ. ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

ХМЗ нь 2015 оноос 2023 оныг дуустал нийт 555 өргөдөл гомдлыг хүлээн авч, 54 удаагийн Ёс зүйн хорооны хурлаар нийт гомдлын 59 хувийг шийдвэрлэж, тус шийдвэрийн 74 хувьд ёс зүйг зарчим зөрчигдсөн гэсэн дүгнэлт гарсан юм.



2023 оны нэгдүгээр сараас арванхоёрдугаар сар хүртэлх хугацаанд нийт 33 өргөдөл гомдлыг хүлээн авч, 19 гомдлыг Ёс зүйн хороодоор хэлэлцүүлсэн. Үүнээс:

- РТВ-ийн Ёс зүйн хороо 10 (53%)
- ССС-ын Ёс зүйн хороо 9 (47%) гомдлыг тус тус хэлэлцсэн байна.



2023 ОНД ХМЗ-Д ИРСЭН 33 ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ:

- 10 гомдлыг гомдол хүлээж авах барагдуулах журам /ГХАБЖ/-ын 2.3-р заалтын дагуу хугацаа хэтэрсэн, материалаа бүрэн бүрдүүлж өгөөгүй, ХМЗ-ийн чиг үүрэгт хамаарахгүй, гомдол үндэслэлгүй зэрэг шалтгаанаар Ажлын албанаас урьдчилсан хяналт хийж шийдвэрлэсэн.
- 3 гомдлыг гомдол гаргагч буцаан татсан.
- 19 сэтгүүл зүйн бүтээлд хаягласан гомдлыг хоёр Хороодын долоон удаагийн хуралдаанаар хэлэлцэж, ГХАБЖ-ын 6.3-ийн дагуу дараах дүгнэлтийг гаргасан.

1. ГХАБЖ-ЫН 6.3.1-ИЙН ДАГУУ

- Surag.mn сайт “Болгарын зохион байгуулалттай гэмт бүлэглэлтэй хамтран компани байгуулсан Энхбаярын Батшугарын оффшор компаниуд” гарчигтай нийтлэл,
- Nuuts.mn сайт “Нууц материалууд: Ширэнгийн хууль”, “Нууц материалууд: Бүртгэлийн мафи” гарчигтай цуврал нэвтрүүлгийг бэлтгэхдээ тухайн редакцууд Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим зөрчөөгүй гэдгийг олон нийтэд мэдээлэв.

2. ГХАБЖ-ЫН 6.3.3-ИЙН ДАГУУ 14 редакцыг Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим зөрчсөн тул нэрийг дурдаж олон нийтэд мэдээлэв.

3. ГХАБЖ-ЫН 3.4-ИЙН ДАГУУ 2 гомдлыг хэлэлцэхийг түр хойшлуулав. Үүнд:

- Neguun.mn сайт 2023 оны дөрөвдүгээр сарын 18-нд түгээсэн нэгэн шууд дамжуулалтаараа худал мэдээлэл түгээж, нэр хүндэд халдсан гэх гомдлыг цагдаагийн алба хаагчаас ирүүлснийг Ёс зүйн хороо шийдвэрлэхдээ гомдол гаргагч буруугүй гэдгээ нотолсон баримт ирүүлээгүй, мөн уг асуудлыг хууль, хяналтын байгууллага шалгаж буй тул эцэслэн шийдэгдэх хүртэл гомдол хаяглагдсан бүтээлд дүгнэлт гаргахыг түдгэлзсэн юм. Энэ нь Хэвлэл мэдээллийн зөвлөл сэтгүүл зүйн бүтээл нь мэргэжлийн стандартаа мөрдөж ажилласан эсэхэд хараат бусаар дүгнэлт гаргадаг бөгөөд аливаа нэмэлт нотлох баримтыг цуглуулж, мөрдөн шалгах ажиллагаа явуулдаггүйтэй холбоотой.
- Zarig.mn сайт 2023 оны аравдугаар сарын 6-ны өдөр шууд дамжуулсан нэр бүхий мэдээллүүдэд хаягласан гомдлыг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн юм. Гомдол гаргагч байгууллага нь шүүхийн байгууллагад давхар хандсан, сэтгүүлч Н.Өнөрцэцэгийг хуулийн байгууллага шалгаж буй тул ХМЗ-ийн Гомдол хүлээн авах, барагдуулах журмын 3.4-т заасны дагуу уг гомдлыг хэлэлцэхийг түр хойшлууллаа.

Ёс зүйн хорооны дүгнэлтээс харахад хариуцагч хэвлэл мэдээллийн редакцууд бүтээлээ бэлтгэхдээ мэдээллээ нягтлах, баримтаар баталгаажуулах ажлаа дутуу хийсэн, эх сурвалжийн тэнцвэрт байдлыг хангаагүй, сэтгүүлчийн хувийн үзэл бодол хэт давамгайлсан, таамаг байж болзошгүй мэдээллийг олон нийтэд хүргэж байгаа ч таамаг гэдгийг илэрхийлэх агуулга бүтээлдээ тусгаагүй зэрэг сэтгүүл зүйн үйл ажиллагааны алдааны улмаас Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын дараах заалтуудыг нийтлэг зөрчжээ. Үүнд:

- 1.1-т заасан “Мэдээлэл нь үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулж, санамсаргүй алдаа гаргахаас зайлсхийнэ” гэсэн заалтыг 21 удаа,
- 1.2-т заасан “Эх сурвалжийн баталгаатай эсэхийг нягталж, тодорхой дурдахыг эрмэлзэнэ” гэсэн заалтыг 12 удаа;
- 1.5-д заасан “Нөлөөллийн болон мэдээллийн бүтээлийг ялгаж, мэдээнд үзэл бодол оруулахаас татгалзана” заалтыг 6 удаа;
- 1.6-д заасан “Баталгаагүй мэдээлэл, таамаглал, ам дамжсан яриаг таамаг хэмээн тодорхой дурдана” гэсэн заалтыг 4 удаа зөрчжээ.

РЕДАКЦУУДЫН НИЙТЛЭГ ЗӨРЧСӨН ЁС ЗҮЙН АЛДААГ ДАРААХ ЖИШЭЭГЭЭР ТАЙЛБАРЛАВ.

ЖИШЭЭ 1: ШЕЗ-өөс ирүүлсэн гомдолд өдөр тутмын нэгэн сонин болон түүний эрхлэн гаргадаг сайтад нийтлэгдсэн “Шударга ёсны талд зогсоно гэсэн шүүгчдийн тоо 100 давжээ” гэх гарчигтай бүтээлийг ёс зүйн зарчим зөрчсөн тухай бичсэн юм.

Тодруулбал, “...Харин 2023 он гарсны дараахан нэр бүхий 30 гаруй шүүгч Ерөнхий сайд, Засгийн газар тэргүүтэй нөхдийн хийж буй ‘шударга ёсны төлөөх тэмцэл’-ийг дэмжиж, ‘Шударга ёсны талд зогсоно’ гэдгээ илэрхийлсэн байдаг. Тэгвэл ингэж байр сууриа илэрхийлсэн шүүгчдийн тоо 100 давжээ. Монгол Улсад 600 гаруй шүүгч бий. Тэдний 20 орчим хувь нь ийн мэдэгдсэн болж таарч байна. Уг нь шударга ёсны талд зогсох нь тэдний хуулиар хүлээсэн үүрэг л дээ. Гэвч явж ирсэн тогтолцоо, томилгоо, бусад хүчин зүйлийн улмаас тухайн шүүгчийн үйл ажиллагаанд саад болдог байна. Хуулийг өөрчилсөн ч ийм хүчин зүйлүүд байсаар байгаа ажээ...” гэсэн агуулгыг гомдол гаргагч тал баримт нотолгоогүй, үзэл бодлоор бичсэн бөгөөд шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлыг үгүйсгэсэн гэж буруутгасан байв.

Ёс зүйн хороо уг гомдлыг хэлэлцэхдээ тухайн редакц нь “...шударга ёсны талд зогсоно гэсэн шүүгчдийн тоо 100 давсан” гэж мэдээлсэн ч үүнийгээ ямар нэг баримтаар баталгаажуулаагүй, нэг ч эх сурвалж дурдаагүй, таамаг байж болзошгүй мэдээллийг олон нийтэд хүргэж байгаа ч таамаг гэдгийг илэрхийлэх агуулга байхгүй, баттай мэдээлэл мэтээр мэдээлсэн, тайлбар өгөхөөр холбогдоход нь боломж олгоогүй тул 1.1, 1.2, 1.5, 1.8 дахь заалтуудыг зөрчсөн гэж үзсэн. Харин гомдол гаргагчийн гомдолдоо дурдсан үг, өгүүлбэрт агуулгыг буруугаар ойлгуулах, хэт хялбарчлах, мэдээллийг мушгин гуйвуулах агуулга байхгүй, нөлөөллийн агуулга байхгүй бөгөөд мэдээ биш тул үзэл бодол орох боломжтой, уг мэдээллийн ташаа гэдгийг хэн ч, ямар ч байдлаар тогтоогоогүй тул 1.3, 1.5, 1.9 дэх заалтуудыг зөрчөөгүй гэж дүгнэсэн билээ.


ЖИШЭЭ 2: “Bloomberg Philanthropies” олон улсын байгууллагаас нэгэн сайтын нэвтрүүлэгт ирүүлсэн гомдолд тус байгууллагын үйл ажиллагааны зорилго чиглэлийг гуйвуулсан, байгууллагын нэр хүндэд халдаж, үндэслэлгүй гүтгэсэн хэмээн дурдсан юм.

Харин редакцын зүгээс хариу тайлбартаа нэвтрүүлгийг хийх болсон хэд хэдэн шалтгааныг тусгасан байлаа.

Ёс зүйн хороо уг гомдлыг хэлэлцээд, редакц нэвтрүүлэгтээ гомдол гаргагч байгууллагын санхүүгийн эх үүсвэрийн талаар мэдээлж байгаа ч түүнийгээ баримтаар нотлоогүй, тухайн мэдээллийн эх сурвалж, баримт уг нэвтрүүлэгт байхгүй гэж үзэн, Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын 1.1, 1.2 дахь заалтуудыг зөрчсөн хэмээн дүгнэсэн юм.

Харин энэхүү бүтээл нь сэтгүүл зүйн “мэдээ” биш бие даасан нэвтрүүлэг тул үзэл бодол, байр суурь, дүгнэлт орох боломжтой, мөн редакц нь гомдолд дурдсан мэдээллээс бусад агуулгаа баримтаар баримтжуулсан, гомдол гаргагч байгууллага тайлбар өгөх оролдлого хийгээгүй, нэвтрүүлгийн үеэр дурдаж буй мэдээллүүд нь худал ташаа гэдгийг аль нэгэн эрх бүхий байгууллага тогтоогоогүй, гомдол гаргагч байгууллага өөрсдийнх нь талаарх мэдээлэл ташаа гэдгийг залруулах баримтаа өгөөгүй нөхцөлд редакц залруулга гаргах боломжгүй, мөн тухайн нэвтрүүлгийн далд сурталчилгаа гэж үзэх үндэслэлгүй тул Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын 1.5, 1.6, 1.8, 1.9, 5.1, 9.1 дэх заалтуудыг зөрчөөгүй гэж үзсэн юм.

ЭНЭ ОНД ХМЗ-Д ГОМДОЛ ГАРГАГСДЫГ АНГИЛЖ ХАРВАЛ:



ХОЁР. УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БОДЛОГЫН ШИЙДВЭРҮҮД:

ХМЗ-ийн Удирдах зөвлөл нь сонин/ сэтгүүл, радио/ телевиз, цахим сайтууд, орон нутгийн хэвлэл мэдээлэл, олон нийт/санаачлагчдын бүлэг гэсэн таван салбар бүлгийг төлөөлөх 15 хүний бүрэлдэхүүнтэй.

ХМЗ НҮТББ-ын дүрмийн 10.2-т заасны дагуу ажлын албанаас санал оруулсан үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг батлах, гүйцэтгэлд хяналт тавих, зөвлөмж, чиглэл өгөхөөс гадна хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг бэхжүүлэхтэй холбоотой бодлогын шийдвэрүүдийг гаргаж ажилладаг.

2023 онд ХМЗ-ийн Удирдах зөвлөл хагас жил тутамд хурлаа хийж, дараах бодлогын баримт бичгүүдийг хэлэлцэн баталжээ.

1. 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн жилийн тайланг хэлэлцэн дүгнэж, 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг батлав. (2-р сарын 16)
2. 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг хэлэлцэн дүгнэж, хоёрдугаар хагас жилийн төлөвлөгөө төсвийг батлав. (6-р сарын 30)
3. Ёс зүйн хороодод сайтын сэтгүүлчийн төлөөллөөр ugug.mn сайтын сэтгүүлч У.Болортуяаг, олон нийтийн төлөөллөөр хуульч, судлаач Л.Галбаатарыг тус тус сонгож, радио, телевизийн эздийн төлөөллөөс сонгогдсон Г.Бат-Эрдэнэ, олон нийтийн төлөөллөөс сонгогдсон Т.Өнөрсайхан, сайтын сэтгүүлчийн төлөөллөөс сонгогдсон Ш.Оюунчимэг нарыг өөрсдийнх нь хүсэлтийн дагуу Ёс зүйн хорооны гишүүнээс чөлөөлөв. (6-р сарын 30)
4. Хэвлэл Мэдээллийн Зөвлөл НҮТББ-ын урт хугацааны тогтвортой хөгжлийн төлөвлөгөөний дагуу Гомдол хүлээн авах, барагдуулах нэгжийн тогтвортой санхүүжилтын загвар болох Хэвлэл мэдээллийн ёс зүйн өөрийн зохицуулалтыг дэмжигч байгууллага үүсгэн байгуулах санаачилгыг бодлогын түвшинд дэмжлээ. (6-р сарын 30)
5. ЮНЕСКО-гийн Монгол дахь комисс, МСНЭ, Хэвлэлийн хүрээлэн, ГИТ, ХЭҮК, Эмнести интернэшнл зэрэг байгууллагуудтай хамтран “Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр”-ийг угтан нэг сарын аяныг зохион байгуулсан. Уг аяны хүрээнд ХМЗ хариуцан зохион байгуулах “Сэтгүүл зүйд хүний эрхийг хангах нь” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав. /4 дүгээр сарын 18/
6. 1-5 дугаар сард “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2023-2030”-ийг боловсруулах ажлын хэсэгт ХМЗ-ийн төлөөлөл ажиллав. Энэ хүрээнд холбогдох уулзалт, семинаруудад оролцон Зорилго 3 буюу Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн байгууллага, хэвлэл мэдээллийн бодит оролцоо, үр дүнтэй хяналтыг бэхжүүлэх хүрээнд саналаа илэрхийлсэн. Мөн “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2023-2030”-ийг боловсруулж, УИХ-д хэлэлцүүлэхээр өргөн барьсан хувилбарын Зорилт 3.4.1; Зорилт 3.4.4; хэсэгт ХМЗ-ийн удирдах зөвлөлийн гишүүд саналаа өглөө.
 - Зорилт 3.4.1. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэн батлуулж, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын эрх, үүргийг тодорхойлно.
 - Зорилт 3.4.4. Сэтгүүлчийн мэргэжлийн хариуцлагыг нэмэгдүүлж, хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг бэхжүүлнэ.
7. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт туссан Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулах ажлын хэсэгт УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос ХМЗ-ийн төлөөлөл оролцох саналыг ирүүлсэн. Уг ажлын хэсэгт УЗ-ийн гишүүн Г.Улсболд, Ёс зүйн хорооны орлогч дарга Ц.Чимиддондог нар ажиллаж, санал дүгнэлтээ

илэрхийлэв. Хуулийн төсөлд ХМЗ-ийн УЗ-ийн албан ёсны саналыг илгээсэн бөгөөд олон нийтийн хэлэлцүүлэгт ХМЗ-ийн Удирдах зөвлөлийн дэд дарга С.Шаравдорж, гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа нар оролцов.

8. ХМЗ-ийн удирдах зөвлөлийн дарга У.Тамир, гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа нар Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгтэй уулзаж, зөвлөлийн үйл ажиллагааг танилцуулахын сацуу цаашдын зорилтуудын талаар санал солилцлоо. Уулзалтад Германы хэвлэлийн зөвлөлийн орлогч дарга Манфред Протце, Дойче Велле Академийн Монголыг хариуцсан хөтөлбөрийн менежер Патрик Беннинг, Дойче Велле Академийн Монгол дахь төлөөлөгч Х.Ариунчимэг нар мөн оролцож Монголд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийнхээ талаар танилцуулав.



9. ХМЗ-ийн санхүүжилтийн тогтвортой байдал нь байгууллагын урт хугацааны хөгжлийн томоохон сорилтын нэг тул хуульчид болон ХМЗ-ийн Удирдах зөвлөлийн төлөөллийн бүрэлдэхүүнтэй дугуй ширээний ярилцлагыг зохион байгууллаа. Ингэснээр ХМЗ-ийн үндсэн үйл ажиллагааг дэмжих хараат бус дэмжигч байгууллага байгуулах санаачилгыг дэмжиж, тус байгууллагын дүрэм, журам, бүтэц бүрэлдэхүүн, стратегийн чиглэлийг тодорхойлоход саналаа өгөв. /9 дүгээр сарын 8/



Улмаар 2023 оны 12-р сарын 07-нд “Хэвлэл мэдээллийн ёс зүйг дэмжигч байгууллага” НҮТББ /Independent Fund for Media Self-Regulation (IFMS)/ нь хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалтын байгууллагыг үүсгэн байгуулагч, санаачилгын бүлгийн нэг Медиа консул клубын анхны идэвхтэй гишүүд болон бизнесийн салбарын төлөөллүүдийн “Ёс зүйт нийгмийн төлөөх” сайн дурын санаачилга, хамтын удирдлагын оролцоотойгоор, хараат бусаар байгуулагдав.



10. Удирдах зөвлөл нь байгууллагын санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг батгаасан 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд Голден Пэйж Аудитын компаниар хараат бус аудитын шалгалт хийлгэж, дүгнэлт, зөвлөмжтэй танилцлаа.



ГУРАВ. СЭТГҮҮЛ ЗҮЙН ЁС ЗҮЙН ФОРУМ 2023

Хэвлэл Мэдээллийн Зөвлөлөөс “Сэтгүүл зүйн ёс зүйн форум”-ыг тав дахь жилдээ “ЁС ЗҮЙН ҮНЭ ЦЭН: ЭРХ ЧӨЛӨӨГӨӨ ХАДГАЛЖ, ИТГЭЛИЙГ ОЛЖ АВАХ НЬ” сэдвийн хүрээнд амжилттай зохион байгууллаа. Нэгдүгээр сарын 27-ны өдөр болсон энэхүү форумд хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлч, редактор, салбарын судлаач, хуульчдын 120 орчим төлөөлөл оролцлоо.

Энэ удаагийн форумгаар “Ёс зүй, итгэл үнэмшлийн эрсдэл: Хэвлэл мэдээлэлд итгэх итгэлийг сэргээх нь” болон “Нэр төр, алдар хүндийн эрүүгийн эрх зүйн хамгаалалт ба хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт” гэсэн сэдвүүдийн хүрээнд хоёр салбар хэлэлцүүлэг өрнүүлэв.

ХМЗ-ийн Удирдах зөвлөлийн дарга У.Тамир форумдыг нээж хэлсэн үгэндээ “Цар тахал, олон улсын энх тайвны ээдрээтэй нөхцөл байдал нь хэвлэлийн эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хумигдах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Үндсэн хуулиар хамгаалагдсан иргэний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд үндэслэлгүйгээр хязгаарлалт хийх, аливаа хэлбэрийн цензур тогтоохоос ардчилсан Монгол улс холуур байх учиртай” хэмээн онцлон тэмдэглэлээ. Мөн ХМЗ-ийн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа “Хэвлэлийн эрх чөлөөг

баталгаажуулахад хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын оруулж буй хувь нэмэр” илтгэлдээ “Хүн хийж байгаа учир алдаа гарна. Алдаа болгон санаатай бас зорилготой байдаггүй. Алдааг нь олж харж, хэлж сануулж, засуулж урагшлахаас аргагүй. Энэ бол хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын мөн чанар. Энэ жишгээр иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн 500 гаруй өргөдөл гомдлыг шүүхээс өмнөх шатанд өөрийн зохицуулалтаар шийдвэрлээд байна” гэлээ.

Энэ мэтээр Ёс зүйн зарчим - олон ургалч байдал, Оролцоог хангах, итгэлийг нэмэгдүүлэх нь, Эрүүгийн хуульд заасан “Худал мэдээлэл тараах гэмт хэргийн зохицуулалт ба практик”, Нэр төр, алдар хүндийн эрүүгийн эрх зүйн хамгаалалт - ХБНГУ болон бусад улс орнуудын туршлага зэрэг сэдвээр дотоодын болон олон улсын мэргэжилтнүүд илтгэл танилцуулав.

Тухайлбал, МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, доктор Д.Идэржаргал “Редакцын түвшинд сэтгүүл зүйн ёс зүйг зохицуулж буй байдал” илтгэлдээ редакцуудын ёс зүйн кодын судалгаа, тэнд мэргэжлийн ёс зүйн асуудалд хэрхэн анхаардаг талаарх практик соёлын судалгаануудаа танилцууллаа. Тэрээр “Хэвлэл мэдээллийн ёс зүй нь хувь сэтгүүлч, редакц, салбарын түвшинд



зохион байгуулагддаг. Монголд ёс зүйн өөрийн зохицуулалт нь байгууллагын буюу редакцын түвшинд хамгийн их алдагдаж байна” хэмээн дүгнэжээ. “Хэдийгээр сэтгүүлчийн ёс зүйн асуудал нь нийгэм болон мэргэжлийн олон хүчин зүйлээс хамаардаг ч хэвлэл мэдээллийн хэрэгслүүд мэргэжлийн ёс зүйн төлөөх наад захын зохион байгуулалт хийхгүй байгаа нь сул тал болж байна” гэлээ. Мөн “Сэтгүүлч ёс зүйтэй ажилласнаар олон нийтийн итгэлийг олж авдаг. Олон нийтийн итгэлийг олж авахын тулд ёс зүйн мэдэгдлүүд хэвлэл мэдээллийн салбарт үгүйлэгдэж буйг онцлов. Өөрөөр хэлбэл ёс зүйгээ баримталж ажилладаг редакцууд мэргэжлийн ямар ёс зүй баримталдаг, үүнийг бүтээлдээ хэрхэн ашигласан зэргээ хэрэглэгчдэдээ тогтмол тайлбарладаг, ил тод мэдээлдэг, сурталчилдаг соёл дутагдаж байгааг онцлов.

Форумын салбар хуралдаанаар Монголын хуульчдын холбооны Зөвлөлийн гишүүн, МУИС-ийн докторант Д.Оросоо, ХБНГУ-ын Вюрцбургийн их сургуулийн Эрүү, эрүүгийн процесс, эрх зүйн онол, компьютер-мэдээлэл зүйн шинжлэх ухааны эрх зүйн тэнхимийн эрхлэгч Проф. Др. Эрик Хилгендорф “Нэр төр, алдар хүндийн эрүүгийн эрх зүйн хамгаалалт - ХБНГУ болон бусад улс орнуудын туршлагаас” сэдэвт илтгэл танилцуулав.

Проф. Др. Эрик Хилгендорф илтгэлдээ “Америк, Их Британид хүмүүсийг харилцан хүндэтгэх тодорхой стандартыг хууль ёсны дагуу биш юм гэхэд ядаж нийгмийн түвшинд хамгаалах зорилго бүхий хөдөлгөөнүүд идэвхтэй өрнөсөөр байна. Ийм зүйлсийг бид анхнаасаа сөрөг байдлаар дүгнэж ерөөс болохгүй. Учир нь эдгээр нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний үр дүн юм. Европт үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнөөс үүдэлтэй асуудлууд нийгмийн сүлжээнд өргөнөөр ажиглагдаж байна. Үүнтэй холбоотойгоор үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хувь хүний үндсэн эрхийг хамгаалах эрх чөлөөгөөр хязгаарлаж болох талтай гэж судлаачид үзэж байна.” хэмээн дурдлаа.

Илтгэгч Д.Оросоо “Эрүүгийн хуульд заасан Худал мэдээлэл тараах гэмт хэргийн зохицуулалт ба практик” илтгэлдээ “Сэтгүүлчдийн дөрөө харшуулж болохгүй зүйл бол гүтгэлэг бөгөөд практикаас харахад сэтгүүлчид хүнийг үндэслэлгүйгээр гүтгэдэггүй” гэлээ. Мөн Монгол улс үг хэлэх эрхийг хамгаалахын зэрэгцээ худал мэдээлэлтэй тэмцэх хэрэгтэй гэдгийг онцолсон юм.

Форумыг Ханнс-Зайделын сан, Дойче Веллэ Академи дэмжлэг үзүүлэн хамтран зохион байгуулсан билээ.

“ЁС ЗҮЙН ҮНЭ ЦЭН: ЭРХ ЧӨЛӨӨГӨӨ ХАДГАЛЖ, ИТГЭЛИЙГ ОЛЖ АВАХ НЬ”

СЭТГҮҮЛ ЗҮЙН ЁС ЗҮЙН ФОРУМААС ГАРСАН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

2017 оноос зохион байгуулж байгаа энэхүү форумыг тухайн жилийн хэвлэл мэдээллийн онцлог сэдэв, хэвлэл мэдээллийн салбарын чиг хандлагыг илэрхийлэх сэдвийг сонгон авч хэлэлцдэг уламжлалтай. Энэ жил бид хэвлэлийн эрх чөлөөгөө хадгалж, буурсаар байгаа олон нийтийн итгэлийг эргэн сэргээхэд сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн үнэ цэн орших юм гэсэн агуулгын хүрээнд санал солилцож, хэлэлцэн байр сууриа илэрхийллээ.

Сэтгүүл зүйн итгэл үнэмшил ёс зүйд суурилж бий болдог, мэргэжлийн ёс зүйн код редакцын бодлоготой хэвлэл мэдээллийн байгууллага олон нийтийн итгэл үнэмшлийг илүүтэй хүртэж, салбартаа өрсөлдөх чадвартай байгааг онцоллоо. Хэвлэл мэдээлэлд итгэх олон нийтийн итгэл жил ирэх тусам буурсаар байгааг дэлхийн хэмжээнд хийгдсэн судалгааны дүн харуулсаар байгаа боловч нарийвчлан авч үзвэл мэргэжлийн ёс зүйгээ мөрддөг, олон нийтийн мэдэх эрхийг тууштай баримталдаг, нийгмийн, эдийн засгийн хууль бус үйлдлийг эрэн сурвалжлагаар баримтаар нотолдог, алдаагаа хүлээн зөвшөөрч залруулж чаддаг хэвлэл мэдээллийн хувьд уншигч, үзэгчид нь үнэнч хэвээр байна. Уншигчид хяналтын үүргээ нэр төртэй биелүүлж буй, ёс зүйтэй хэвлэл мэдээллийг үнэлэх төдийгүй санхүүгийн дэмжлэг үзүүлж буйгаас мэргэжлийн ёс зүй ямар чухал болохыг оролцогчид онцолсон юм.

Ёс зүйн кодоо олон нийтэд ил болгосноор тухайн байгууллагын нэр хүнд, итгэл нэмэгдэх эерэг нөхцөл болохыг илтгэгч Д.Идэржаргал санууллаа. Мэргэжлийн ёс зүйг дагаж мөрдөхөөс гадна тодорхой төрлийн контентоор дагнан төрөлжих, улс төрийн чиг баримжаагаа олон нийтэд зарлах, хэвлэл мэдээлэлд нийгмийн бүхий л бүлэг, давхарга, хүйсийн оролцоог нэмэгдүүлэх, уншигч, үзэгчийнхээ хүсэл сонирхолд нийцсэн контентийг бэлтгэн хүргэх нь итгэлийг дээшлүүлэх арга замууд мөн болохыг оролцогчид илэрхийллээ.

Сэтгүүлчдийн бэлтгэсэн цуврал нэвтрүүлгүүд мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдэж, тэдгээр контентийг бэлтгэн олон нийтийн мэдэх эрхийг хангасных нь төлөө уншигч, үзэгчид нь мөнгөн хандиваар тогтвортой ажиллах боломжийг нь хангаж байгаа эерэг жишээнүүдийг ч дурьдав.

ХМЗ-өөс өнгөрсөн жилээс хэрэгжүүлж байгаа “Мэдрэмжтэй мэдээлье” төсөлд хамрагдсан редакцуудын хувьд мэдээллийн эх сурвалжийн хүрээ тэлж, тэр хэрээр мэдээ нийтлэлийн агуулга баяжин, хэрэглэгчийн тоо нэмэгдсэн нь итгэлийг нэмэгдүүлэх бас нэг сайхан жишээ болж байна.

Редакц болгон ёс зүйн кодтой больё, ёс зүйн соёлыг бий болгоё, ёс зүйтэй ажилладаг хэвлэлүүд бодлого, процессоо сурталчилъя, олон нийтийн хэвлэл мэдээллийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн контент бэлдэхийг уриалж байна.

Форумын үеэр хөндсөн хоёр дахь сэдэв нь хүний нэр төр, алдар хүндийг гутаасан хэргийг болон гүтгэлгийг Эрүүгийн хуулиар шийдвэрлэх нь зөв үү, эсвэл Иргэний хуулиар шийдвэрлэх ёстой юу гэсэн хэлэлцүүлэг байлаа. Гүтгэх доромжлох хэргийг Эрүүгийн хуулиар шийдэхгүй байх, энэ заалтыг сэтгүүлчдэд илүүтэй хамаатуулахгүй байх байр суурийг хэвлэл мэдээллийнхэн олон жилийн турш илэрхийлсээр ирсэн.

2017 онд Эрүүгийн хуулиас гүтгэх, доромжлох заалтыг хасч Зөрчлийн хуулиар зохицуулах болсон нь бодит амьдралд нийцэхгүй байгааг хуулийнхан ч, хэвлэл мэдээллийнхэн ч идэвхтэй шүүмжилснээр 2019 онд Эрүүгийн хуульд “Худал мэдээлэл тараах” гэсэн тодорхойлолтоор буцаан оруулж одоо зохицуулж байгаа нь амьдралд нийцэж байгаа эсэх талаар оролцогчид эсрэг тэсрэг байр суурийг илэрхийллээ.

Эрүүгийн хуулийн энэхүү заалтыг сэтгүүлчдийн мэргэжлийн ёс зүйн зөрчилд хамаатуулан

шийдвэрлэх аюулыг бий болгож байгааг, худал мэдээлэл, гүтгэлэг гэдгийг нэг мөр ойлгох зайлшгүй шаардлага байгааг онцоллоо. Эрүүгийн хуульд өмнө байсан гүтгэх, Зөрчлийн хуульд оруулсан гүтгэх, одоо Эрүүгийн хуульд тусгасан худал мэдээлэл гэсэн заалтуудаар улс төрийн албан тушаалтан илүүтэй сэтгүүлчдийн эсрэг гомдол гаргаж байгааг статистик харуулж байгаа юм. Сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагааг хамгаалах эрх зүйг сайжруулах, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг өргөнөөр ашиглахыг форумын үеэр онцоллоо.

Монголын олон нийт, тэр дундаа хэвлэл мэдээллийнхний анхаарлыг онцгой татаж

байгаа Цахим орчинд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн үр дагавар ямар байх талаар оролцогчид байр сууриа илэрхийллээ. Энэхүү хуулийг УИХ-аас яаралтай горимоор 2023 оны нэгдүгээр сарын 18-ны өдөр баталсан нь хууль тогтоомжийн тухай хууль, УИХ-ын чуулганы дэгийн тухай хуулийг зөрчиж, хуулийн хэрэгжилтэд хамаатай олон талын оролцоог хангаагүй, хуулийн хэрэгжилтийн үр дагаварыг тооцоогүй, хуулийг хэрэгжүүлэх явцад буруугаар ашиглагдах, мушгин гуйвуулах эрсдэлтэй гэж үзлээ. Энэхүү хуульд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2023 оны нэгдүгээр сарын 30-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан байна.

**ФОРУМЫН ҮР ДҮНД ТУЛГУУРЛАН ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ
ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД САНАЛ БОЛГОЖ БАЙНА.**

1. Цахим орчин, технологийн хөгжил дагасан мэдээллийн “шуурга” дунд хэвлэл мэдээллийн нийгэмд төдийгүй ардчилалд гүйцэтгэх үүрэг улам тодорч байна. Ийм үед редакц, сэтгүүлчид өөр хоорондоо төдийгүй нийгмийн сүлжээнээс мэргэжлийн ёс зүйн үнэ цэнээрээ улам бүр ялгарч манлайлах.
2. Хэвлэл мэдээллийн байгууллагууд мэргэжлийн ёс зүйг сахиж мөрдөхөөс гадна ялгарал, эгэх хариуцлага, хэрэглэгчидтэйгээ нягт холбоотой байснаар тогтвортой бөгөөд хараат бус байдлаа байдлаа хадгалж хамгаалах.
3. Олон нийтийн итгэл үнэмшлийн төлөөх ёс зүйн өрсөлдөөнийг редакцууд дунд дэмжсэн олон талт ажлуудыг хэрэгжүүлэх.
4. Редакц бүр ёс зүйн зарчим, редакцын бодлоготой болж түүнийгээ мэдээлж сурталчлах, тайлагнах зэргээр ил тод ажиллаж хэрэглэгчийнхээ итгэлийг дээшлүүлэх.
5. Сэтгүүлчид, редакцууд цахим орчинд хүний эрхэд хүндэтгэлтэй хандах, нийгмийн сүлжээнд үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийн хамгаалагч, сайн жишиг нь байх.
6. Хүний нэр төр, алдар хүндийг эрх зүйн хүрээнд хамгаалахдаа сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааг урвуулан ашиглахгүй байх, ёс зүйн өөрийн зохицуулалтыг өргөнөөр ашиглаж хэвших.
7. “Гүтгэх”, “доромжлох”, “худал мэдээлэл тараах”, “илт худал мэдээлэл”, “нэр төр, алдар хүндэд халдах” зэрэг нэр томъёог хоёрдмол утгагүйгээр тодорхойлж хуулийнхан болон хэвлэл мэдээллийнхэн нэгдсэн ойлголтод хүрэх.
8. Хэвлэлийн эрх чөлөөнд хамаарах хууль тогтоомжийг хэлэлцэх, батлах явцад хууль тогтоомжийн хууль болон хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг анхааралтай ажиглах, харилцан ярианд суурилсан нэгдсэн ойлголцлоор сайжруулж болох илүү хувилбаруудыг дэвшүүлж хэвших.

Улаанбаатар хот
2023 оны 02 дугаар сарын 08

ДӨРӨВ. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БОДЛОГО: ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ БЭХЖҮҮЛЭХ НЬ



1-3 ДУГААР САРД

Хэвлэл мэдээллийн зөвлөл салбартаа хэр хүлээн зөвшөөрөгдсөн, үйл ажиллагаа нь сэтгүүлчид, редакцад үр нөлөө үзүүлж чадаж буй эсэхэд олон улсын эксперт хараат бус судалгаа хийж зөвлөмжийг ХМЗ-д хүлээлгэн өгөв. Уг хараат бус судалгааг Данийн Вант Улсын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах зөвлөх ноён Пер Осторланд, Монголын чөлөөт сэтгүүлч Б.Анандтай хамтран 2023 оны нэгдүгээр улиралд хийж гүйцэтгэв. ХМЗ нь хэвлэл мэдээллийн салбартаа хүлээн зөвшөөрөгдөж, нэр хүнд, итгэл үнэмшилтэйгээр үйл ажиллагаагаа амжилттай явуулж байгаа хэмээн судалгаанд оролцсон сэтгүүлчдийн 90 орчим хувь хариулжээ. Түүнчлэн ХМЗ нь хэвлэл мэдээллийн салбарын ёс зүй, эрх зүйт системийг бэхжүүлэх, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалахад үр нөлөө бүхий дуу хоолой болж байр сууриа бэхжүүлсэн байна хэмээн судлаачид дүгнэжээ. Цаашид олон нийтийн оролцоо дэмжлэгийг нэмэгдүүлэх, ёс зүйн хорооны шийдвэрийг өргөн хүрээнд түгээн сурталчлах, санхүүжилтийн урт хугацааны тогтвортой байдлаа бэхжүүлэх, үйл ажиллагааны цар хүрээгээ улам өргөжүүлэх зэрэг санал зөвлөмжийг судлаачид тусгасан байв.



4-5 ДУГААР САР

ЮНЕСКО, МСНЭ, ГИТ, ХЭҮК, Хэвлэлийн хүрээлэн, Эмнести интернэшнл зэрэг байгууллагуудтай хамтран “Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр”-ийг угтсан аян зохион байгуулав. Ингэхдээ “Ирээдүйн эрхээ бүтээх нь: Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хүний эрхийг хангах хөшүүрэг мөн” уриан дор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, мэдээлэл авах эрх, эрх чөлөөний эрх зүйн орчны тулгамдсан асуудал, хэвлэл мэдээллийн хариуцлага, ёс зүй, сэтгүүлчдийн аюулгүй байдал, хэвлэл мэдээллийн хөгжлийн чиг хандлагыг ил тодоор хэлэлцэж, асуудал дэвшүүлэх, шийдэл эрэлхийлэх, эв санааны нэгдлээ илэрхийлэх аяныг дөрөвдүгээр сарын 14-нөөс эхлэн тавдугаар сарын 3-ныг хүртэл хэвлэлийн хурал, хэлэлцүүлэг, форум зэргийг зохион байгуулсан. Энэ хүрээнд холбогдох уулзалт, хэлэлцүүлэгт оролцсоноос гадна Сүхбаатарын талбайд Үзэл бодлоо илэрхийлэх эрх, хэвлэлийн эрх чөлөөний төлөөх эв санааны нэгдлээ илэрхийлэх акад оролцлоо.





2-9 ДҮГЭЭР САР

Хэвлэл мэдээллийн зөвлөл “Редакцын уулзалт”-ыг тогтмол зохион байгуулсаар ирсэн билээ. Энэ хүрээнд 40 гаруй редакцын хамт олонтой уулзсан байна. Энэхүү уулзалтаар хэвлэл мэдээллийн салбарын өөрийн болон эрх зүйн зохицуулалтын зааг ялгааг тайлбарлаж, редакцуудад “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-аа сахин ажиллахад нь мэдлэг, мэдээлэл, зөвлөмж өгдөг.

Энэ хүрээнд Монцамэ агентлаг, graph.mn болон ergelt.mn-ний сэтгүүлчидтэй уулзаж, салбарын өөрийн зохицуулалтын үр дүнг танилцуулан, хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын түгээмэл алдааны талаар хэлэлцэж, сэтгүүлчийн аюулгүй байдал, хууль эрх зүйн өөрчлөлт, салбарын шинэ чиг хандлага, сэтгүүл зүйн чанарыг дээшлүүлэх талаар санал солилцлоо.

Дээр нэр дурьдсан редакцууд “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-ыг сахин мөрдөхөө илэрхийлж, “Редакцын ёс зүйн амлалт” баримт бичигт нэгдлээ.



5 ДУГААР САРД

Тавдугаар сарын 30-ны өдөр ГИТ-өөс зохион байгуулсан “Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг бэхжүүлэх нь” уулзалт, семинарт УЗ-ийн гишүүн Г.Тэгшжаргал, гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа, төслийн менежер Н.Ганчимэг, төслийн зохицуулагч А.Амартүвшин нар оролцов. Уулзалтыг Глоб Интернэшнл төвийн УЗ-ийн тэргүүн Х.Наранжаргал, УЗ-ийн гишүүн Л.Галбаатар, хуульч О.Төрболд нар чиглүүлж, “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба нэр хүнд гутаах гэмт хэрэг-Олон улсын хэм хэмжээ”, “Хэвлэлийн эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний өнөөгийн нөхцөл байдлыг үнэлж, эрүүгийн хуульд нэмж оруулах 13.15 дугаар зүйлийн төсөл (Доромжлох) ба үндэсний эрх зүйн зохицуулалтын онцлог”, “Доромжлох” үйлдлийн ойлголт, хэв шинж, Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцсоноос үүдэн гарах үр дагавар” сэдвийн хүрээнд болов.



7-12 ДУГААР САРД

Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн үндэсний хөтөлбөрийн 2021-2023 оны тайлан танилцуулах уулзалтад оролцож, холбогдох саналаа хүргүүлсэн. Мөн 2024-2027 оны Үндэсний үйл ажиллагааны V төлөвлөгөөний төсөл боловсруулж танилцуулах Ажлын хэсэгт багтан хоёр удаагийн хуралдаанд оролцож хэвлэлийн эрх чөлөөг хамгаалан бэхжүүлэх, иргэний орон зайг тэлэх, иргэний нийгмийн хараат бус байдал, тогтвортой хөгжлийг дэмжих эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлд санал хүргүүлэв.



10 ДУГААР САРД

ХМЗ-ийн бүх гишүүдийн ээлжит сургалт, семинар аравдугаар сарын 28-нд болсон. Сургалтад ХМЗ-ийн Удирдах зөвлөл, ёс зүйн хороод болон ажлын албаны 30 орчим төлөөлөл хамрагдлаа. Энэ үеэр ХМЗ-ийн хараат бус зөвлөх Д.Нарантуяа Ёс зүйн хорооны хурлын шийдвэр, хэрэгжилтэд анхаарах санал зөвлөмж өгөв. Мөн РТВ-ийн ёс зүйн хорооны гишүүн Д.Идэржаргал Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчимд нэмэлт өөрчлөлт оруулах, үндэслэл, хэрэгцээ шаардлагын талаар ярьсан бол Радио, Телевизийн ёс зүйн хорооны орлогч дарга Ц.Чимэддондог, Сонин, сэтгүүл, сайтын ёс зүйн хорооны дарга Х.Болормаа нар ёс зүйн зарчимд нэмэлт өөрчлөлт оруулах хороодын саналыг танилцуулсан юм. Сургалтын үр дүнд гишүүдийн ёс зүйн зарчимд оруулах саналуудыг харьцуулан судалж, эцэслэн нэгтгэхээр ажлын хэсэг байгууллаа.





10-12 ДУГААР САРД

Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг шинэчлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулав. ХМЗ-ийн бүх гишүүдийн 2022 оны сургалтаас гарсан саналыг тусгаж, 2023 оны сургалтаар ахин хэлэлцүүлж, гишүүдийн саналыг авсан. Сургалтын үеэр гишүүдийн саналыг эцэслэн бэлтгэх ажлын хэсэг байгуулан нэг удаагийн хэлэлцүүлэг хийж, ёс зүйн зарчмын өөрчлөлтийн төсөл бэлтгэсэн. Үүнийг гишүүдэд цахимаар танилцуулж, нэмэлт санал авч Ажлын алба ахин боловсруулав. Үүний дараа 30 орчим салбарын эвсэл, холбоод, холбогдох байгууллагад явуулж саналаа өгөхийг хүссэн. Хүсэлтийн дагуу Орон нутгийн телевизүүдийн холбоо болон Глоб интернэшнл төвөөс саналаа ирүүллээ.



11 ДҮГЭЭР САРД

- Соёлын яамнаас санаачлан зохион байгуулсан “Хэвлэл мэдээлэл ба хүүхэд хамгаалал” сэдэвт салбар дундын хэлэлцүүлэг арваннэгдүгээр дүгээр сарын 9-ний өдөр болсон. Энэ үеэр ХМЗ-ийн ёс зүйн хорооны гишүүн, Peak.mn сайтын эрхлэгч Ц.Цэрэндолгор “Хүүхдийн асуудлыг сурвалжлах арга зүй” сэдвээр илтгэл танилцуулав. Мөн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа “Хэвлэл мэдээллийн салбарт хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал” сэдэвт салбар хэлэлцүүлэгт оролцож санал солилцлоо.



- “Сэтгүүлчдийн эсрэг гэмт үйлдэл, ял шийтгэлгүй үлдэж буйг таслан зогсоох Олон улсын өдөр”-ийг тохиолдуулан Хэвлэл мэдээллийн зөвлөл, Глоб Интернэшнл төв, ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комисстой хамтран 11 дүгээр сарын 02-ны өдөр “Сэтгүүлчдийн эсрэг зөрчил, сонгуулийн шударга байдал болон олон нийтийн манлайллын үүрэг” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт ХМЗ-ийн ССС-ын Ёс зүйн хорооны дарга Х.Болормаа, тус зөвлөлийн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа, төслийн менежер А.Амартүвшин нар оролцож мэдээлэл хийлээ.



12 ДУГААР САРД

- ХХЗХ-ны дэмжлэгтэйгээр 12 дугаар сарын 13-ны өдөр “Сонгуулийн үеийн хэвлэл мэдээллийн манлайлал: Ёс зүйтэй нягталъя” сэдэвт сэтгүүлч, редакторуудад зориулсан сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Сургалтад 30 орчим оролцогч оролцож Хэвлэл мэдээллийн байгууллагуудын хуурамч, худал мэдээлэлтэй тэмцэх, ёс зүйтэй сурвалжлах редакцын өөрийн зохицуулалтын талаар санал бодлоо солилцон, мэдээллийг нягтлан шалгах Олон Улсын чиг хандлагыг танин мэдэх туршлагаас суралцлаа. Оролцогчдын зүгээс сонгуулиар хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмаа баримтлан ажиллахад хэвлэн нийтлэх эрхэд халдаагүй хууль, дүрэм журмын боловсруулалт хэрэгтэйг онцолсон юм. Түүнчлэн редакторуудын зөвлөлдөх уулзалтыг 2024 оны нэгдүгээр улиралд зохион байгуулж, сонгуулийн үеэрх дүрэм, журмын талаар хэлэлцэхийг санал болгосон юм.



- Сонгуулийн хуульд эмэгтэйчүүдийн квотыг нэмэгдүүлэхэд ХМЗ болон “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдэл дэмжлэг үзүүлж, хамтран ажиллалаа. Улс төрийн намуудын жендэрийн тэгш эрхийн төлөө амлалт, өөрчлөлтийн асуудлыг “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдлийн зарим гишүүд сурвалжилж 101 сэтгүүл зүйн бүтээлийг өнгөрсөн жилд бэлтгэсэн юм. Түүнчлэн “Жендэрийн мэдрэмжтэй эрх зүйн шинэчлэлийн манлайлагчид” хүндэтгэлийн арга хэмжээг 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Жендэрийн үндэсний хороо, “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдэл, “Эмэгтэйчүүдийн манлайллын сүлжээ” хамтран зохион байгуулж “Жендэрийн мэдрэмжтэй эрх зүйн шинэчлэлийн манлайлагчдыг” тодруулсан юм.



- Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж буйтай холбогдуулан 12 дугаар сарын 15-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулж, төслөө танилцуулсан. Тус хэлэлцүүлэгт УЗ-ийн дарга У.Тамир оролцсон бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Хэвлэл мэдээллийн зөвлөл саналаа хүргүүлэх нь зүйтэй гэж үзсэний үндсэн дээр Удирдах зөвлөлийн гишүүдээр хэлэлцүүлсэн саналыг бичгээр хүрүүлэв.
- Сонгинохайрхан дүүргийн прокурорын газрын 2023.12.01-ний өдрийн 116 тоот зөвшөөрөл, Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны 9/6-8665 тоот шийдвэрийг тус тус үндэслэн zarig.mn цахим хуудаст Монгол улсаас хандах эрхийг хязгаарлах арга хэмжээг Харилцаа холбооны зохицуулах хорооноос авсан нь сэтгүүл зүйн үйл ажиллагаа, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг шүүхийн шийдвэргүйгээр, захиргааны байгууллагаас хязгаарласан ноцтой асуудал үүсгэж, улмаар олон нийтийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хэтрүүлэн хязгаарлахын зэрэгцээ сэтгүүл зүйн үйл ажиллагаанд төрийн байгууллагуудын шууд оролцоотойгоор цензур тогтоож байгааг Хэвлэл мэдээллийн салбарын мэргэжлийн байгууллагууд болох Хэвлэл мэдээллийн зөвлөл, Глоб Интернэшнл төв эрс буруушаан эсэргүүцэж, мэдэгдэл гаргав.



МЭДЭГДЭЛ

Сонгинохайрхан дүүргийн прокурорын газрын 2023.12.01-ний өдрийн 116 тоот зөвшөөрөл, Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны 9/6-8665 тоот шийдвэрийг тус тус үндэслэн zarig.mn цахим хуудаст Монгол улсаас хандах эрхийг хязгаарлах арга хэмжээг Харилцаа холбооны зохицуулах хорооноос авсан нь сэтгүүл зүйн үйл ажиллагаа, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг шүүхийн шийдвэргүйгээр, захиргааны байгууллагаас хязгаарласан ноцтой асуудал үүсгэж, улмаар олон нийтийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хэтрүүлэн хязгаарлахын зэрэгцээ сэтгүүл зүйн үйл ажиллагаанд төрийн байгууллагуудын шууд оролцоотойгоор цензур тогтоож байгааг Хэвлэл мэдээллийн салбарын мэргэжлийн байгууллагууд болох Хэвлэл мэдээллийн зөвлөл, Глоб Интернэшнл төв эрс буруушаан эсэргүүцэж байна.

Тус цахим хуудаст Монгол Улсаас хандах хандалтыг хязгаарлах арга хэмжээг ийнхүү авсан нь Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг хясан боогдуулаад зогсохгүй Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд тусгасан “Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй” гэсэн заалтыг шууд зөрчсөн үйлдэл болжээ.

Төрийн байгууллагын албан хаагчид хувь хүнд үүсгэсэн хэргийг мөрдөн шалгах хүрээнд хэвлэл мэдээллийн байгууллага, редакцын нийт сэтгүүлчдийн бие даасан үйл ажиллагааг хязгаарлах санаачилга гарган хэрэгжүүлснээр цахим орчинд олон нийтийн мэдээлэл авах, түгээх эрхэд халдаж, хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд ноцтой гажуудал бий болгож буйд бид харамсаж байна.

НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын төрөлжсөн байгууллага буюу ЮНЕСКО-гийн “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба хэвлэл мэдээллийн хөгжлийн дэлхийн чиг хандлага”-ын тайланд “гүтгэх, доромжлох үйлдлийг эрүүлжүүлэх нэрээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлах явдал дэлхий даяар нэмэгдэж байна. Гүтгэх, доромжлохтой холбоотой асуудлыг шүүхийн бус журмаар буюу хэвлэлийн зөвлөл зэрэг хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын механизмаар шийдвэрлэх нь зүйтэй байна” гэж дүгнэсэн.

Гэтэл сэтгүүлч Н.Өнөрцэцэгийг худал мэдээлэл тараасан гэх үндэслэлээр хилээр гарахыг хориглосон ба мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхийг хязгаарлах талаар шүүхээс хэлэлцсэн, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйтэй холбоотой асуудлыг эрүүгийн хэргийн журмаар мөрдөн шалгаад зогсохгүй zarig.mn цахим хуудсыг зөрчилтэй домайн нэрийн жагсаалтад оруулсан нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг баталгаажуулсан олон улсын гэрээ, Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцэхгүй байгааг анхаарч, Сонгинохайрхан дүүргийн прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах алба зэрэг Төрийн байгууллагууд сэтгүүл зүйн үйл ажиллагаанд цензур тогтоохгүй байх, Харилцаа холбооны зохицуулах хороо zarig.mn сайтыг зөрчилтэй домайн нэрийн жагсаалтад оруулсан шийдвэрээ эргэн харж яаралтай арга хэмжээ авахыг шаардаж байна.

Хэвлэл мэдээллийн зөвлөл

Глоб Интернэшнл төв

2023 оны 12 дугаар сарын 03

Улаанбаатар хот

ТАВ. ОЛОН НИЙТЭД ХАНДСАН АЖЛУУД:

- ХЭҮК-оос зургаадугаар сарын 9-ний өдөр “Хүний эрх хамгаалагч-Ёс зүй” сэдвийн хүрээнд зохион байгуулсан сургалт, уулзалтад гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа оролцож “Сэтгүүлчдийн ёс зүйн зөрчил, аюулгүй байдал” сэдвээр илтгэл танилцуулсан. Уг уулзалтад Өдрийн сонин, Ваарбар.mn, Gogo.mn, Eagle.mn, Isee.mn, Ivoice.mn, Tsaхиur.mn, Tug.mn, Zugii.mn, Ubn.mn, Unuudur.mn, Ugluu.mn, See.mn, Eagle TV зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслийн 15 сэтгүүлч хамрагдлаа. (Зургаадугаар сар)




- Сонгогчдын өдөрлөгт оролцож ХМЗ-ийн үйл ажиллагааг иргэдэд таниулан сурталчлав. Тодруулбал, НҮБХХ-өөс хэрэгжүүлж буй Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь төслийн хүрээнд 6-р сарын 3-нд Сонгогчдын өдөрлөгийг УИД-ийн урд задгай талбайд зохион байгуулав. Уг арга хэмжээнд Сонгуулийн Ерөнхий Хороо, Жендэрийн Үндэсний Хороо зэрэг төрийн байгууллагуудаас гадна Сонгогчдын боловсрол төв, Бодлогод залуусын хяналт, Сэтгүүл зүйн үүр төв, ХМЗ зэрэг төрийн бус байгууллагууд оролцов. ХМЗ-өөс “Мэдрэмжтэй мэдээлье” хөтөлбөрийн хүрээнд хийсэн ажлуудаа танилцуулахаас гадна ХМЗ-д гомдол хэрхэн гаргах талаар танилцуулга мэдээлэл хийж, холбогдох гарын авлагуудыг тараасан юм. (Зургаадугаар сар)



- Хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, иргэдэд хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллагын ач холбогдлыг таниулах ажлын хүрээнд “Үндэсний номын баяр”-аар зочилж буй уншигчдад мэдээлэл өглөө. (Есдүгээр сар)



- Хэвлэлийн эрх чөлөө, олон нийтийн мэдэх эрх, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй зэрэг хэвлэл мэдээллийн салбарыг тойрсон сэдвүүдийн талаар мэргэжлийнхний тайлбар, байр суурийг олон нийтэд хүргэх зорилгоор “Бидний подкаст” нэртэй цуврал подкаст бэлтгэн түгээв. Эхний дугаарт Хэвлэл мэдээллийн зөвлөлийг үүсгэн байгуулагчдын нэг, ёс зүйн хорооны анхны гишүүн, ХМЗ-ийн хараат бус зөвлөх, сэтгүүлч Д.Нарантуяа, хоёр дахь дугаарт ХМЗ удирдах зөвлөлийн гишүүн, ХИС-ийн багш Л.Ариун нар оролцлоо. (Арванхоёрдугаар сар)



- ХМЗ-өөс санаачлан “Редакцын буухиа” хамтарсан контентыг эхлүүлж, “Мэдрэмжтэй мэдээлье” менторшип хөтөлбөрт хамрагдсан найман редакцаар аялан сурвалжлах ажлыг эхлүүллээ. Энэхүү хамтарсан контентын үр дүнд уг найман редакцын сувгаар болон mediacouncil.mn, tentsuu.mn платформын нийт 10 сувгаар 80 удаа ёс зүйтэй, жөндөрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйг хөгжүүлж буй сайн туршлагыг уншигч, үзэгч, сонсогчдод түгээн сурталчиллаа. Редакцын буухиан зорилго нь ёс зүйтэй, мэргэжлийн сэтгүүл зүйн байгууллагуудыг олон нийтэд таниулан сурталчлах, хэвлэл мэдээллийн нэр хүнд, итгэл үнэмшлийг нэмэгдүүлэхэд чиглэж байна. (Арванхоёрдугаар сар)



- ХМЗ-ийн 2023 оны үйл ажиллагаа, хүлээн авч шийдвэрлэсэн өргөдөл гомдлын талаарх багц мэдээлэл бүхий цахим сэтгүүлийг улирал тутамд монгол, англи хэл дээр бэлтгэж олон нийтэд түгээсэн. Мөн цахим сэтгүүлийг сошиалаар түгээж хүртээмжийг нэмэгдүүлэв. Цахим сэтгүүлийг улирал тутамд тогтмол 1400 гаруй хүнд илгээдэг бөгөөд тэдгээрийн 80 орчим хувь нь тогтмол уншиж байна.

- Хэвлэл мэдээллийн зөвлөлийн хараат бус зөвлөх Д.Мөнхчимэгийн “Д.Мөнхчимэг: Виртуал редакцтай ажиллаж байгаа сэтгүүлчид олон янзын дуу хоолой, байр суурийг гаргаж, бүтээлээ илүү тэнцвэртэй болгоход анхаарч байна.” гарчигтай тодруулга Ub.life сайтад нийтлэгдэв. (2023.04.18)

Д.Мөнхчимэг: Виртуал редакцтай ажиллаж байгаа сэтгүүлчид олон янзын дуу хоолой, байр суурийг гаргаж, бүтээлээ илүү тэнцвэртэй болгоход анхаарч байна

Хөтөлбөрийн талаар “Мэдрэмжтэй мэдээлэл” виртуал редакцын редактор Д.Мөнхчимэгээс тодрууллаа.

- Виртуал редакц хэрэгжээд гурав дахь сардаа орж байна. Хамтран ажиллаж буй сэтгүүлчдийн бүтээлийн чанар, өнцөг, хийцийн хувьд ямар ахиц дэвшил ажиглагдаж байна?

-Жендэрийн эрх тэгш байдлын талаарх сэтгүүл зүйн бүтээл Монголд маш ховор гардаг байсан. Тухайлбал, Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс улс төрийн мэдээллийн агуулгад хийсэн мониторингийн судалгаанаас үзэхэд нийт контентын ердөө 1.8 хувь нь л жендэрийн тэгш, тэгш байдлын талаар дурдсан байв. Тэдгээрээс яг үл суурьтай, даацтай бүтээл мөн ховор.

Тиймээс бид жендэрийн сэдвээр чанартай бүтээл хийх сэтгүүлчдийг дэмжих зорилгоор “Мэдрэмжтэй мэдээлэл” виртуал редакц ажиллуулж эхлүүлээд байна. Нэгдлийн зүгээс өнгөрсөн хоёр жилийн хугацаанд маш олон сургалт, тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлж ирсэн. Тэдгээр хөтөлбөрт хамрагдсан сэтгүүлчид маань бүтээл хиймээр байна, менторуудтайгаа үргэлжлүүлэн ажилламаар байна гэсэн хүсэлт гаргасны дагуу энэ үйл ажиллагааг эхлүүлээд байгаа юм.

Олон улсын сэтгүүлчид нэг бүтээл хийхийн тулд маш олон хүнтэй уулзаж, судалгаа хийдэг. Тэр цаг хугацааг ч редакцаас нь гаргаж өгдөг, бүтээлийн урамшуулал нь ч манайхтай харьцуулахад хэдэн арав дахин өндөр. Мөн бүтээл дээр сэтгүүлч төдийгүй редактор, фактчекер гээд багаараа ажилладаг учраас чанартай бүтээл гарахаас ч аргагүй байдаг. Харин манай сэтгүүлчид асар их ачаалалтай, цаг нартай уралдаж ажилладаг шүү дээ. Гадны сэтгүүлч нэг бүтээл хийхдээ хэдэн долоо хоног биш юмаа гэхэд хэдэн өдөр зарцуулж байхад манай сэтгүүлчид нэг өдөрт хэд хэдэн мэдээ, контент гаргана. Тиймээс энэ их ачаалалтай орчинд нь тохируулж, жендэрийн сэдвээр даацтай бүтээл хийхэд нь туслах үүднээс бид эх сурвалжийн дата сан, судалгаа зэргийг нь ойртуулсан мэдээллийн багц бэлтгэж өгч байгаа. Мөн би редакторын хувьд сэтгүүлчидтэйгээ бүтээлийн санаа гаргахаас нь эхлээд өнцөгөө илүү тодорхой болгох, ашиглаж болох судалгаа, ярилцаж болох эх сурвалжуудыг санал болгох зэргээр ажиллаж байна. Ингээд ажиллахаар сэтгүүлчдийн бүтээл яах аргагүй чанаржиж байна. Виртуал



- “Сэтгүүл зүйн Ёс зүйн форум”-2023-ын үеэр гүйцэтгэх захирал Г. Гүнжидмаагийн “Олон нийтийн итгэлийг олоход сэтгүүл зүйн ёс зүй өндөр байх хэрэгтэй” гарчигтай ярилцлага epress.mn, polit.mn сайтад нийтлэгдэв. (2023.01.26). Мөн үеэр News.mn сайтыг сурвалжилгад оролцож ярилцлага өглөө.



Г.Гүнжидмаа: Олон нийтийн итгэлийг олоход сэтгүүл зүйн ёс зүй өндөр байх хэрэгтэй

09:08 1 САРЫН 26, 2023 169

Facebook Twitter LinkedIn Google+

С.УЯНГА
Хэвлэл мэдээллийн салбарынхан “Ёс зүйн үнэ цэн: Эх чөлөөгөө хадгалж, итгэлийг олж авах нь” сэдвийн дор маргаш цуглрах гэж байна. Форумтай холбоотойгоор Хэвлэл мэдээллийн зөвлөлийн Гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаатай ярилцлаа.

Г.Гүнжидмаа: Олон нийтийн итгэлийг олоход сэтгүүл зүйн ёс зүй өндөр байх хэрэгтэй

© 2023-01-26

Нийтэлсэн: Админ

© 8 Мөн үндэж



- Хэвлэл мэдээллийн зөвлөлийн төслийн менежер А.Амартүвшин хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааны талаар Eagle телевизэд ярилцлага өглөө. (2023.11.02)



- Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба мэдэх эрхийн хэрэгжилт-2023 олон талт хэлэлцүүлгийн үеэр ХМЗ-ийн гүйтцэтгэх захирал Г.Гүнжидмаа zarig.mn сайтад ярилцлага өглөө. (2023.12.20)





ЗУРГАА. “ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ НЬ” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД:

ХМЗ нь хариуцлагатай, ёс зүйтэй, олон ургалч хэвлэл мэдээллийг дэмжиж ажилладаг бөгөөд хэвлэл мэдээллийн агуулгад жендэрийн тэгш байдлыг хангах, жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйг хөгжүүлэх, хэвшмэл хандлагаас зайлсхийх ёс зүйн зарчмын хүрээнд уг төсөл дээр хамтран ажиллаж байна. Уг ажлын хүрээнд энэ онд дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

- “Мэдрэмжтэй мэдээлье” төслийн хүрээнд хэрэгжүүлэх 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хяналт-үнэлгээний мониторингийн аргачлал гаргах, үйл ажиллагааны төсөв бэлтгэх ажлуудыг гүйцэтгэж, 2-р сарын 8-нд хамтын ажиллагааны гэрээг сунгав.
- “Мэдрэмжтэй мэдээлье” төслийн 2021 оны үйл ажиллагаанд мониторинг хийх, санхүүгийн гүйцэтгэлд хяналт шалгалтыг БНЭУ-ын мэргэшсэн аудитын байгууллагаар хийлгэж зөрчилгүй дүгнэлт авч, мөн зарим сайжруулах саналыг хүлээн авав.
- “Мэдрэмжтэй мэдээлье” форумыг амжилттай зохион байгуулж, жендэрийн тэгш байдлын төлөө манлайллыг олон улсад харуулахыг зорилоо. Форумд 100 гаруй сэтгүүлч, редакторууд болон жендэрийн тэгш эрхийн төлөө ажилладаг судлаач, мэргэжилтнүүд олон ургалч үзэл, хандлага, ёс зүйтэй сэтгүүл зүйг хөгжүүлэхэд гарч буй дэвшил, өөрчлөлтийн талаар хэлэлцсэн юм.
- Жендэрийн эрх тэгш байдлын тухай ёс зүйтэй бүтээл гаргахад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий “Виртуал редакц”-ыг үүсгэж, Виртуал редакцын 2023 онд 9 сэдвийн хүрээнд нийт 101 бүтээлийг сэтгүүлчдээс хүлээн авч, хамтран ажиллалаа.
- Монгол Улсад “Media journalism” буюу хэвлэл мэдээллийн тухай сэтгүүл зүйг хөгжүүлэх эхлэлийг тавьж, мэргэжлийн редакцууд хэрхэн яаж ажиллаж буйг хэрэглэгчдэд таниулан сурталчлах зорилгоор “Редакцын буухиа” хамтарсан контентыг өнгөрөгч онд эхлүүлсэн билээ. Бид хамтдаа 8 контентыг 80 сувгаар хүргэлээ. Энэхүү контентыг “Зууны мэдээ” сонин, ТВ9, “Шинэ өсөлт” сэтгүүл, GoGo.mn, Ergelt.mn, Ub.life, Peak.mn, Eguur.mn сайтууд хамтран бүтээлцсэн юм.
- “Мэдрэмжтэй мэдээлье” редакцын менторшип хөтөлбөр 2023 онд амжилттай үргэлжилж, 6, 8, 9, 10 дугаар сард Zuv.mn, TV9, Eagle TV, Eguur.mn сайтын редакцуудад хөтөлбөрийг хэрэгжүүлэн 94 сэтгүүлч, уран бүтээлчийг хамрууллаа. Энэ хугацаанд нийт дөрвөн редакцаас жендэрийн хэвшмэл ойлголтыг халсан, шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш эрхийн асуудлыг хөндсөн 33 бүтээл гарав.
- Эмэгтэй эх сурвалжийн дата санг ТВ9 телевиз, Монцамэ агентлаг, Зөв.мн сайтуудад хүлээлгэн өгөв.
- Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо сэдвээр фото зургийн нээлттэй мэдээллийн санг 2023 оныг дуусталх хугацаанд 80 зургаар бүрдүүлж Монголын гэрэл зургийн агентлагийн тpa.



mn сайтад “Мэдрэмжтэй мэдээлье” цэсийг нээж байршуулав. Гэрэл зургийг виртуал редакцын бүтээлүүдийг баяжуулахад болон төслийн үйл ажиллагаанд ашиглалаа.

- “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдэл, төслийн нэгдсэн платформ болох tentsuu.mn сайтыг сурталчлах уулзалтуудыг (4 удаа) зохион байгуулж, “Оролцоно төлөөлнө” өдөрлөгт оролцож мэдээлэл түгээлээ.
- Сэтгүүлчид, “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдлийн гишүүдэд хандсан улирал тутмын цахим ньюслеттерийг бэлтгэж, улирал тутам 250 орчим хүнд хүргэсэн.
- Менторшип болон тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан сэтгүүлчид “Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо” сэдвээр бүтээл хийх ур чадвартай, сонирхолтой болсон боловч цаашдаа хамтран ажиллах суваг, боломжоор хангах зорилгоор “Мэдрэмжтэй мэдээлье” виртуал редакц нь 4 удаа вебинар зохион байгуулав.
- “Өөрөөс нь” уулзалтыг 8 дугаар сард зохион байгуулж, ХМЗ-ийн хараат бус зөвлөх Д.Мөнхчимэг хэвлэл мэдээллийн байгууллагын редакторуудтай туршлага солилцлоо. Уулзалтад нийт 12 ерөнхий редактор оролцов. Уулзалтын үр дүнд Монгол Улсад хэвлэл мэдээллийн тухай сэтгүүл зүй /media journalism/-ыг хөгжүүлэхэд томоохон хувь нэмэр оруулах “Редакцын буухиа” шинэ санаачилгыг эхлүүлээ. Үүнд “Зууны мэдээ” сонин, GoGo.mn, Ub.life, Ergelt.mn, Peak.

mn, “Шинэ өсөлт” сэтгүүл, Eguur.mn, TV 9 редакцууд оролцлоо.

- “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдлийн сайн туршлагаас 8 дугаар сарын 29-нд Интерньюс Олон Улсын байгууллагын хамт олонд цахимаар танилцуулж, тус уулзалтад 65 орны төлөөлөл оролцлоо. Уулзалтын үр дүнд “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдлийн тухай Интерньюс Олон Улсын байгууллага онцолж нийтлэн , Global Investigative Journalism Network энэ тухай дахин мэдээлсэн юм.
- “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдлийг мөн Монгол дахь Азийн сангийн 20 гаруй ажилчдад 9 дүгээр сард танилцуулав. Уулзалтын үр дүнд Монголын хэвлэл мэдээллийн эерэг үр дүн болон хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын дагуу жендэрийн мэдрэмжгүй, хохирогчийг буруутгасан, хэвшмэл ойлголтыг бататгасан, хүйс, гэр бүлийн байдлаар ялгаварлан гадуурхсан сэтгүүл зүйн бүтээлд гомдол гаргаж, хэлэлцүүлэх боломжтой тухай мэдээллийг тайлбарлав.
- Хэвлэл мэдээллийн зөвлөлийн хараат бус зөвлөх Д.Мөнхчимэг 2023 оны 8-р сард Их Британий Чевнингийн тэтгэлэгт хөтөлбөрт шалгарч “Gender and Media” чиглэлээр боловсролын зэрэг хамгаалахаар суралцаж байна. Тэрээр нэгдлийн үйл ажиллагааг гадаадад таниулан сурталчлах ажлыг идэвхжүүлж Women’s Media Center байгууллагатай хамтын ажиллагаа эхлүүлэв.

- “Сонгогчдын боловсрол төв”-өөс зохион байгуулсан “Амлалтаараа нэгдье” өдөрлөгт 9 дүгээр сарын 17-ны өдөр оролцож, “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдлийн үйл ажиллагааг 300 гаруй иргэдэд сурталчилж, шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш эрхийн асуудлын чухлыг тайлбарлалаа.
- 2023 оны арванхоёрдугаар сард “Редакцын буухиа” хамтарсан контент, аяны туршлага, үр дүнг хуваалцах зорилгоор “Мэдрэмжтэй мэдээлье” редакторуудын уулзалтыг зохион байгуулав.
- Сонгуулийн үеэр редакцууд гарын авлага болгон ашиглах 70 нүүр удирдамжийг боловсрууллаа. Удирдамж нь сонгуулийн өмнөх шат буюу “Улс төр дэх жендэрийн тэгш бус байдлыг сурвалжлахаасаа өмнө юуг анхаарах вэ?”, сонгуулийн үеэр “Улс төр дэх жендэрийн тэгш бус байдлын сэдвээр бүтээл хийх нь”, сонгуулийн дараа “Сонгуулийн үр дүнг жендэрийн мэдрэмжтэй мэдээлэх нь” агуулгын хүрээнд бэлгэгдсэн юм.






ДОЛОО. “ХЯМРАЛЫН МЭДЭЭЛЛИЙН ХАРИЛЦАА БА ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД:

Хэвлэл мэдээллийн зөвлөл нь иргэдийн мэдэх эрхийг хангах, ёс зүйтэй, баталгаатай, найдвартай мэдээллийг түгээн дэлгэрүүлж, хэвлэлийн эрх чөлөөг бататган хамгаалахад хувь нэмрээ оруулдаг салбарын өөрийн удирдлагын байгууллага билээ. Энэ зорилгынхоо хүрээнд мэдээллийн хоёр чигт урсгалыг дэмжих, мэдээллийн хүртээмж сул, алслагдсан хороо, сумдын иргэдэд баталгаат мэдээллийн үнэ цэнийг ойлгуулах, худал ташаа мэдээллийн хор уршгийг таниулах, урьдчилан сэргийлэх, мэдээллийн харилцаанд оролцогч талуудын хамтын ажиллагааг дэмжихэд хувь нэмрээ оруулж буй юм.

Энэ хүрээнд ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн холбооны яам, Дойче Велле Академийн дэмжлэгтэйгээр “Хямралын мэдээллийн харилцаа ба оролцогч талуудын хамтын ажиллагаа” төслийг 2021-2023 онд хэрэгжүүлсэн. Тус төсөл нь Кени, Замби, Киргиз, Молдав, Монгол зэрэг дэлхийн таван оронд хэрэгжсэн олон улсын төсөл билээ. Монгол Улс хоёр дахь жилдээ амжилттай хамрагдаж, 2023 оны нэгдүгээр улиралд төслийг үргэлжлүүлэн дараах ажлуудыг хийсэн юм. Үүнд:

- Хямралын мэдээллийн харилцааны бичил төслийг хэрэгжүүлэх Үйл ажиллагааны баг II нь төсөл хэрэгжүүлэх зорилтот газар болох Чингэлтэй дүүргийн 17 дугаар хороотой танилцах аялал хийж, иргэдийн мэдээлэл түгээж буй болон хүлээн авч буй байдал, хороонд тулгамдаж буй гамшиг, эрсдэлийн асуудалтай танилцлаа. (2023.1 сар)
- Үйл ажиллагааны баг II-н гишүүд “Хямралын мэдээллийн харилцаа: Оролцогч талуудын хамтын ажиллагаа” төсөл хэрэгжиж буй бусад орнууд болох Кени, Замби, Молдав, Киргизстан улсын төслийн багтай туршлага солилцох цахим уулзалтад оролцож, Монгол Улсын багийн үйл ажиллагааг танилцуулав. (2023.1 сар)
- Үйл ажиллагааны баг II нь Чингэлтэй дүүргийн 17 дугаар хороонд “Цахим орчин дахь худал мэдээллийг ялган таних” болон “Цахим орчин дахь үе тэнгийн дээрэлхэлтээс сэргийлэх” гэсэн сэдвийн дор мэдээллийн багц бэлтгэн хэрэгжүүллээ. Мэдээллийн багцын хүрээнд телевизийн сурвалжилга 1, гарын авлага 1, сонины сурвалжилга 2, сайтын сурвалжилга 3, видео хичээл 2, видео нэвтрүүлэг 4, уулзалт, сургалт, хэлэлцүүлэг, үйл явдал 6-г зохион байгуулж, сошиал медиа пост, постер 20 гаруйг бэлтгэн түгээв. (2023.2-3 сар)
- Сэлэнгэ аймагт Үйл ажиллагааны баг III нь төр, хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлтэйгөөр байгуулагдаж, чадавхжуулах сургалтад хамрагдлаа. (2023.1-2 сар)
- Үйл ажиллагааны баг III нь Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд хилийн бүс нутагт оршин суугаа малчид болон хилчдийн хоорондын зөрчил маргааныг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор баталгаат мэдээллийн багцыг бэлтгэн түгээв. Энэ хүрээнд видео нэвтрүүлэг 1, телевизийн мэдээ сурвалжилга 1, сонины тусгай дугаарыг 1000 хувь, малчид болон хилчдийн хооронд ойлголцлын уулзалт 1, аймгийн удирдлагууд болон бусад оролцогч талуудын удирдлагад төслийн үр дүнг танилцуулсан уулзалт 1 удаа тус тус зохион байгуулж, сошиал медиа пост, постер 10 гаруйг бэлтгэн түгээсэн. (2023.2-3 сар)
- Төслийн үр дүнг дүгнэх, оролцогч талуудад таниулах, цаашдын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох дугуй ширээний өргөтгөсөн уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтад хөтөлбөрт оролцогч талуудын төлөөлөл болох хэвлэл мэдээлэл, төрийн байгууллагууд болон иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллүүд оролцсон бөгөөд тус хөтөлбөрийг хоёр дахь жилдээ амжилттай хэрэгжсэн хэмээн дүгнэлээ. (2023.3 сар)



НАЙМ. СЭТГҮҮЛ ЗҮЙН ЧАНАРЫГ ДЭМЖИХ СУРГАЛТ, УУЛЗАЛТУУД

Хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг соёлын салбарынханд таниулан сурталчлах зорилгын хүрээнд дараах үйл ажиллагаануудыг хийж гүйцэтгэв.



Аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газрын дарга, соён гэгээрлийн мэргэжилтнүүдэд зориулсан “Үнэн бодит мэдээллийг таньж мэдэх, нягтлан шалгах тухай” цахим сургалтыг 2023 оны 8 дугаар сарын 29, 30-ний өдрүүдэд зохион байгуулав. Сургалтад 50 гаруй оролцогчид идэвхтэй оролцлоо.



“Сэтгүүл зүйд соёлыг илэрхийлэх нь” гурван удаагийн цуврал цахим сургалтыг СУИС-ийн Соёлын сургуультай хамтран 2023 оны 09, 10 дугаар сард зохион байгуулав. Сургалтад давхардсан тоогоор нийслэл болон орон нутгийн 83 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнууд оролцлоо. Үүнээс цуврал сургалтад бүтэн хамрагдсан 18 сэтгүүлчдэд батламж олгов.



“Гэмт хэргийг ёс зүйтэй сурвалжлах нь” гарын авлагыг 55 нүүрт багтаан боловсруулж, бэлтгэлээ. Энэхүү гарын авлагын агуулгаар хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг тайлбарлаж, гэмт хэрэг, осол, гамшгийн талаар мэдээлэхэд анхаарах зөвлөмжүүдийг оруулав. Мөн жендэрт суурилсан хүчирхийлэл, архи, тамхины асуудлыг сурвалжлах болон хүүхэд хамгааллын асуудалд хэвлэл мэдээлэл хэрхэн анхаарах тухай зөвлөмжийг орууллаа.



Хэвлэл мэдээллийн ёс зүй, салбарын өөрийн зохицуулалтын тухай редакцуудад зориулсан удирдамжийг 40 нүүрт багтаан боловсруулж бэлтгэлээ. Тус редакцын удирдамжаар хэвлэлийн эрх чөлөө ба өөрийн зохицуулалтын механизмын ач холбогдлыг тайлбарлав. Мөн Хэвлэл мэдээллийн зөвлөлийн шийдвэрлэсэн гомдлуудад хийсэн дүн шинжилгээг хавсаргаж, ХМЗ-д хэрхэн гомдол гаргах тухай орууллаа.



ЕС. МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГААНЫ ХЭВЛЭМЭЛ БҮТЭЭГДЭХҮҮН

ХМЗ-өөс 2023 онд дараах гарын авлага, танилцуулга, тараах материал, сурталчилгааны бүтээгдэхүүнийг бэлтгэж, хэвлэл мэдээллийн салбарынхан болон бусад зорилтот бүлэгт түгээв.

- “ХМЗ-ийн 2021- 2022 оны үйл ажиллагааны тайлан” Монгол, Англи хэлээр
- “Хямралын мэдээлэл харилцаа ба оролцогч талуудын хамтын ажиллагаа II” төслийн хэрэгжилтийн тайлан
- “Баталгаатай мэдээлэл амьдралыг аварна” гарын авлага
- Хэвлэл мэдээллийн ёс зүй, салбарын өөрийн зохицуулалтын тухай гарын авлага
- “Гэмт хэргийг ёс зүйтэй сурвалжлах нь” гарын авлага

АРАВ. ДОТООДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ТҮНШЛЭЛ

- Тавдугаар сард Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгад өгөх саналыг Хүний эрхийн үндэсний комисс гаргаж Хүний эрхийн тайландаа оруулсан. Энэ талаар ХЭҮК-ийн төлөөллүүдтэй уулзалт хийж санал солилцов.
- Зургаадугаар сарын 16-ны өдөр ХЭҮК-ын гишүүн Г.Нарантуяатай өглөөний уулзалт хийж, ХМЗ-ийн үйл ажиллагаа, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг бэхжүүлэх хэрэгцээ шаардлагыг танилцуулж, мөн “Мэдрэмжтэй мэдээлье” хөтөлбөрийн сайн туршлагыг хуваалцан цаашид хамтран ажиллах боломжийн талаар ярилцсан. Уулзалтаар хамтарсан ажлын төлөвлөгөө гаргаж, хүний эрхийг хамгаалах, хэвлэлийн эрх чөлөөг бэхжүүлэхэд хамтран ажиллах гарц шийдэл хайхаар тохиролцов.
- Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах РТВ-ийн хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих орон тооны бус зөвлөлд ХМЗ-ийг төлөөлөн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа ажилласан. Ингэхдээ тус зөвлөлийн ажлын хэсгийн хоёр удаагийн хуралд оролцож, РТВ-ээр цацагдсан уран сайхны кино, реклам зар сурталчилгаа, радио нэвтрүүлэг зэрэгт хүүхдэд сөрөг нөлөө үзүүлэхүйц агуулга байсан хэмээн хаягласан 4 гомдлыг хэлэлцэхэд оролцсон.
- 6-р сарын 14-нд болсон Глоб Интернэшнл төв болон ИНБ-дын хамтран зохион байгуулсан “Нийгмийн сүлжээн дэх хүний эрхийн асуудал, шийдвэрлэх арга зам, олон улсын туршлага” хэлэлцүүлэгт ХМЗ-ийн төлөөллүүд оролцов.
- 6-р сарын 15-нд Нээлттэй нийгэм форумас зохион байгуулсан “Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАФТ) болон Монголын төрийн бус байгууллагын хууль: Монголын иргэний орон зайд үзүүлэх үр дагавар ба хувилбарууд” хэлэлцүүлэгт ХМЗ-ийн төлөөллүүд оролцов.



АРВАН НЭГ. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Төв Азийн Хэвлэл мэдээллийн зөвлөлүүдийн сүлжээтэй холбоо тогтоож Казакстаны KazMediaNetwork сүлжээнээс хамтын ажиллагааны саналыг хүлээн авав. Тус сүлжээ нь Төв Азийн хэвлэл мэдээллийн зөвлөлүүдийн үйл ажиллагааг таниулан сурталчлах, харилцан туршлага судлах, хамтын ажиллагаа хөгжүүлэх зорилготой бөгөөд ХМЗ-тэй хамтран ажиллах санамж бичгийн төслийг ирүүлсэн. Мөн энэ хүрээнд тус сүлжээний гишүүдтэй цахим уулзалт хийв.
- Хэвлэл мэдээллийн салбарын эрх зүйн орчинг сайжруулах, хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулах, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэх чиглэлээр ажилладаг олон улсын байгууллагууд болох Европын Холбоо, Дойче Велле Академи, НҮБ-ын суурин төлөөлөгчийн газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Европын Аюулгүй байдал, Хамтын ажиллагааны нийгэмлэг, Ханнс-Зайделын сан, ВВС, Интерньюс, Дэлхийн эрэн сурвалжлах сэтгүүл зүйн сүлжээ, Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн зэрэг байгууллагуудтай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлээ.
- ХМЗ-өөс сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн Хямралын мэдээллийн харилцаа-оролцогч талуудын хамтын ажиллагаа төслийн үр дүнг танилцуулах, хэлэлцэх уулзалт ХБНГУ-ын Бонн хотноо болж, ХМЗ-ийн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа, төслийн менежер Н.Ганчимэг нар оролцов. Уулзалтад Кени, Замби, Киргиз, Молдав зэрэг орнуудын төлөөлөл ирж, харилцан туршлага солилцсон бөгөөд Монгол Улсад хэрэгжсэн төсөл нь аливаа хямрал, гамшиг, ослын үед төдийгүй нийгэмд тулгамдсан бүхий л асуудлыг шийдвэрлэхэд түшиглэж болохуйц хамтын ажиллагааны загварыг таниулснаараа ач холбогдолтой байлаа хэмээн үнэлэв.
- Ардчиллын тулгуур багана: Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг бэхжүүлэх нь дугуй ширээний ярилцлагад оролцсон талууд болон Европын Холбооны төлөөлөгчдөд талархлын захидал илгээв. Мөн Европын Холбооноос зарласан МУ-д Иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхуулах нь төслийн тэтгэлэгт уралдаанд оролцож төсөл хэрэгжүүлэгчээр шалгарлаа.
- НҮБХХ-ийн дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөх хороо (ИНЗХ)-ны гишүүнээр ХМЗ 2023 онд сонгогдож, зөвлөлийг төлөөлөн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа ажлын хэсгийн уулзалтуудад оролцож байна. Уг зөвлөлийн зорилго нь НҮБХХ-ийн дэмжих тэргүүлэх чиглэлүүдийн хүрээнд иргэний нийгмийн байгууллагуудын дуу хоолойг сонсох, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэж байна. НҮБХХ-ийн Иргэний нийгмийн зөвлөх хороо (ИНЗХ) нь НҮБХХ-ийн зөвлөх статустайгаар үйл ажиллагаа явуулдаг ба НҮБХХ болон иргэний нийгмийн байгууллагуудын хоорондын зөвлөлдөх үйл явцыг удирдан чиглүүлэх зорилгоор 2000 онд байгуулагдсан механизм юм. Тус хорооны гол зорилго нь иргэний нийгмийн байгууллагын манлайлагчид болон НҮБХХ-



ийн менежмент хоорондын харилцааг зохицуулахад оршдог.

- “Мэдрэмжтэй мэдээлье” форумын хүрээнд Интерньюс ОУБ-ын төлөөлөл Пуала Орландаг урьж оролцуулан форумд илтгэгчээр оролцуулав. Мөн форумын сэтгүүлчдэд зориулсан сургалтыг зохион байгууллаа.
- Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (OSCE)-аас Төв Азийн орнуудын сэтгүүлчдэд зориулан жил бүр зохион байгуулдаг “Ардчиллыг хамгаалахын тулд хэвлэлийн эрх чөлөөг бэхжүүлэх нь” сэдэвт олон улсын хуралд ХМЗ-ийн төлөөллүүд болох гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа, төслийн менежер А.Ариунтуяа нар оролцлоо.

ХМЗ-ийн Гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа “Сэтгүүл зүйн төлөөлөл: хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт” сэдвээр илтгэл танилцуулж, Монголын хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын үүсгэл санаачилга, төлөвшил, цаашдын чиг хандлагын талаар туршлагаасаа хуваалцлаа. Тэрээр “ХМЗ нь бүс нутагтаа сайн туршлага болохуйц салбарын өөрийн зохицуулалтыг сэтгүүлчид, редакторууд, эвсэл холбоодын хамтын ажиллагаан дор амжилттай хэрэгжүүлж байна” гээд цаашид үйл ажиллагааныхаа тогтвортой байдлыг хангахад олон нийтийн оролцоо, дэмжлэг нэн чухал болохыг онцлов. Мөн энэ үеэр ХМЗ-ийн төслийн төслийн менежер А.Ариунтуяа “Худал ташаа мэдээлэлтэй тэмцэхэд иргэний нийгмийн байгууллагуудын үүрэг, оролцоо” сэдвээр илтгэл танилцуулсав.

Тэрээр ХМЗ-өөс өнгөрсөн жилүүдэд хэрэгжүүлсэн “Хямралын үеийн мэдээлэл харилцаа ба оролцогч талуудын хамтын ажиллагаа”, “Мэдрэмжтэй мэдээлье” зэрэг хөтөлбөрийн хүрээнд сэтгүүл зүйн бүтээлийн чанарыг дээшлүүлэх, ёс зүйн кодыг мөрдүүлэх замаар худал ташаа мэдээлэлтэй тэмцэж буй туршлагаасаа хуваалцсан юм. Энэ үеэр Төв Азийн орнууд болох Казахстан, Киргизстан, Узбекистан, Тажикстаны хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулав.

- Монгол Улсыг хариуцан ажилладаг Тайланд Улс дахь Европын Холбооны Төлөөлөгчийн газрын Хамтын ажиллагааны газрын дарга Daniel Nachez, Европын Холбооны CSO-LA хөтөлбөрийн төслийн уралдаанд шалгарсан байгууллагын төлөөллүүдтэй уулзалт хийлээ. Тус уулзалт нь 2023 оны 11 сарын 20-нд ЕХ-ны Төлөөлөгчийн Газрын хурлын танхимд болсон ба уг уулзалтаар ХМЗ-өөс Иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхжуулан бэхжүүлэх төслийн хүрээнд хийх үйл ажиллагааг танилцуулав. Уулзалтад ЕХ-ны Монгол дахь төлөөлөгчийн газрын програмын менежер М.Бямбарагчаа, ДВА-ийн Монгол дахь хөтөлбөр хариуцсан менежер Патрик Беннинг, ХМЗ-өөс гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа, төслийн санхүүгийн менежер А.Ариунтуяа нар болон бусад шалгарсан байгууллагуудын төлөөлөл оролцов.
- НҮБХХ-ийн “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн үйл ажиллагаанд

хөндлөнгийн үнэлгээ хийж буй “Korean Development Institute”-ийн төлөөлөгчид ХМЗ-д зочилж төслийн багтай үнэлгээний уулзалт хийв. Уг уулзалтад төслийн багийн гишүүд болон ХМЗ-ийн гүйцэтгэх захирал оролцож, өнгөрсөн гурван жилийн хугацаанд “Мэдрэмжтэй мэдээлье” хөтөлбөрийн хүрээнд сэтгүүлчид, редакцуудад хандсан үйл ажиллагаанууд, түүний шинэлэг байдал, үр нөлөө, амжилт ололт, саад бэрхшээлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөв. Төслийн үнэлгээний багийн зүгээс Мэдрэмжтэй мэдээлье хөтөлбөрийн үр дүнг өндрөөр үнэллээ.

- Азийн Сангаас USAID-н дэмжлэгтэйгээр Хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхжуулах урт хугацааны хөтөлбөрийг эхлүүлж буй бөгөөд хэвлэл мэдээллийн салбарт хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэгч IREX олон улсын байгууллагын төлөөллүүдийг хүлээн авч уулзав. Уг уулзалтад гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа, төслийн менежер А.Амартүвшин, А.Ариунтуяа нар оролцож

холбогдох мэдээлэл өгч харилцан санал солилцов.

- “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдлийн сайн туршлагаас 8 дугаар сарын 29-нд Интерньюс Олон Улсын байгууллагын хамт олонд цахимаар танилцуулж, тус уулзалтад 65 орны төлөөлөл оролцлоо. Уулзалтын үр дүнд “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдлийн танилцуулгыг Интерньюс байгууллага цахим хуудсандаа онцолж гаргасан юм.
- Европын Холбоо болон ЭСЯ-уудтай хамтын ажиллагаа өрнүүлэх, харилцан мэдээлэл солилцох уулзалт, арга хэмжээнүүдэд оролцож ХМЗ-ийн талаар мэдээлэл өгч хамтын ажиллагааг өргөжүүлэхэд анхаарч ажиллалаа. Тодруулбал, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсаас Монгол Улсад суугаа ЭСЯ, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын ЭСЯ, Словянын ЭСЯ, АНУ ЭСЯ-тай хэвлэлийн эрх чөлөө, иргэний орон зай, иргэний нийгмийг бэхжүүлэх талын уулзалт арга хэмжээнүүдэд оролцож мэдээлэл солилцлоо.




АРВАН ХОЁР. САНХҮҮЖИЛТ

2023 онд ХМЗ нийт 651,196,739.90 төгрөгийн мөнгөн орлоготой, нийт 724,852,178.55 төгрөгийн мөнгөн зардалтай ажиллажээ. Орлогын бүрдэлт: дотоод эх үүсвэр 4.3%, төсөл хөтөлбөрийн эх үүсвэр 95.7%.



Орлогын эх үүсвэр нь хэвлэл мэдээллийн байгууллагуудын дэмжлэг, сургалт үйлчилгээний орлого, төслийн үйл ажиллагааны орлогоос бүрдэж байна. ХМЗ-ийн үйл ажиллагааны зардлыг төрлөөр харуулбал:



2023 онд хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг дэмжсэн байгууллагууд



2023 онд хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг дэмжсэн байгууллагуудад талархал ирэхийлбэ